# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Эрүүл мэндийн яам

## 2022 оны жилийн эцэс

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| | 6 | | 14.4.. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгсэл болон хүний нөөцөд тавих шаардлагыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага стандартын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батална. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр Барилга байгууламж: нийт 5 тасгийг их засварт оруулсан. /Насанд хүрэгчдийн цочмог эр,эм тасаг, хүүхдийн уушгины тасаг, уушгины 2-р тасаг, сүрьеэгийн сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний их засвар болон агааржуулалтын нэгдсэн систем хүчилтөрөгчийн асуудлыг шийдсэн/. Өвчтөний иж бүрэн функциональ ор -100 ширхэг, компьютертомографи, дижитал рентген аппарат суурилуулсан. | 100% | | |
| | 8 | | 21.6.. Хувийн хэвшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, клиник, түргэн тусламжийн төвөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх энэ хуулийн 18.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, сонгон | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах" УБ-01/008 тоот гэрээ байгуулсан. 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс он дуустал гэрээнд шаардлаагатай оношийн хамаарал бүхий бүлгүүдийн тоо хэмжээг тооцоолж ажилласан ба нийт 20 төрлийн тусламж, | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгаруулах болон гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Засгийн газар батална. | үйлчилгээний 12 удаагийн 240 нэхэмжлэл ЭМДЕГ-т хүргүүлж хамтран ажиллаж байна. | | | |
| | 26 | | 10.4.5.. Энэ хуулийн 10.4.1-д заасан судалгаанд үндэслэн хүүхдийн зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргаж, мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах; (10.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Хот, хөдөө орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагын нийт 1700 эмч, ажилтанд Зонхилон тохиолдох гэдэсний халдварт өвчин болон хоол хүнсний аюулгүй байдлын талаар цахим сургалтыг зохион байгуулсан. | 100% | | |
| | 32 | | 7.1.11.. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг | Ковид-19, Улирлын томуу, томуу төст өвчний бэлэн байдлыг хангах эрсдэлийн харилцааны чиглэлээр үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд: Цуврал 20 контент түгээн нийт Боловсролын ерөнхий газартай хамран Ерөнхий боловсролын 843 сургууль, Цэцэрлэг-1253, Их дээд сургууль-64, коллеж-76, ӨМТ, Аймаг дүүргийн эрүүл мэндийн газруудын цахим суваг анги тэнхимийн дэлгэцээр түгээн 460.337 (11 сарын эхний 7 хоногийн байдлаар) хүнд хүргэн ажилласан. ХӨСҮТ-ийн хэмжээнд | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | авч хэрэгжүүлнэ:) | халварт өвчинтэй холбоотой 2022 оны 1-12 сарын хугацаанд:<br>• Цаг үеийн байдлаад Live 50<br>• Постер зөвлөгөө 260<br>• 7 хоногийн тойм мэдээ 52<br>• Зөвлөгөө шторк 40<br>• Vlog 1<br>• Их эмч нэврүүлэг 4<br>• Залруулга мэдээлэл 10 #factcheck хийгдсэн. | | | |
| | 40 | | 7.1.23.. цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | • Улсын онцгой комиссын даргын 05 дугаар "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө", ЭМС-ын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/33 дугаар тушаалаар "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу хүн амыг үе шаттай дархлаажуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж ажилласан.<br>• Монгол Улс 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн БНХАУ-ын Синофарм үйлдвэрийн Вероцелл, Пфайзер БиоНТех үйлдвэрийн Комирнэти, БНЭУ-ын Ийлдэс судлалын хүрээлэнгийн АстраЗенека-Ковишилд, БНСУ-ын СК Биосайнс үйлдвэрийн АстраЗенека, ОХУ-ын Н.Ф. Гамалеи | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэрэмжит үндэсний эрдэм шинжилгээний төвд үйлдвэрлэсэн Спутник буюу Гам-КОВИД-Вак нийт 8,317,750 хүн тун вакциныг хүлээн авч, зорилтот бүлгийн хүн амаа вакцинжуулах үйл ажиллагааг зохион байгуулж, амжилттай үргэлжилж байна.<br><br>• Энэ хүрээнд эрэмбэлэлтийн дагуу 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн насанд хүрсэн иргэд, 06 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 16-17 насны хүүхэд, 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 12-15 насны хүүхдийг үе шаттайгаар нэг ба хоёрдугаар тунд хамруулан, 08 дугаар сарын 16-ны өдрөөс эрүүл мэндийн байгууллага болон коронавируст халдварын эсрэг хариу арга хэмжээний багт ажилладаг мэргэжилтнүүдэд дархлаа сэргээх нэмэлт 3-р тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг улс орон даяар хийж байна. 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн архаг суурь өвчтэй болон 55-аас дээш насныханд, 09 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 18-аас дээш насны нийт иргэдэд дархлал сэргээх 3-р тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.<br><br>Улсын хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Ковид-19-ын эсрэг вакцины зорилтот бүлгийн 1-р тунгийн хамралт 89.6 хувь, 2-р тунгийн хамралт 85.7 хувь, 3-р тунгийн хамралт 53,7 хувь, нийт хүн амын 1-р тун 68,9 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хувь, 2-р тун 66,0 хувь, 3-р тун 32,0 хувь тус тус хамралттай байна. Өссөн дүнгээр 3-р тунд 1,058,808 хүн, 4-р тунд 139,604 хүн хамрагдсан байна. Өссөн дүнгээр 5-11 насны 3,446 хүүхэд, 12-15 насны 158,948 хүүхэд, 16-17 насны 79,547 хүүхэд, жирэмсэн эмэгтэй 6,428, хөхүүл эмэгтэй 8,020 тус тус 1-р тунд хамрагдаад байна.<br><br>• Эрүүл мэндийн яамнаас 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 04-ний өдрийн хооронд Ковид-19-ын эсрэг вакцинжуулалтын ажлыг эрчимжүүлэх сарын болзолт аяныг аймаг, дүүргийн ЭМБ-ын дунд зарлан зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд НҮБ-ын Хүүхдийн сан санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Сарын аяны хүрээнд Ковид-19 вакцинжуулалтанд улсын хэмжээнд 22407 хүн хамрагдсан ба 1-р тунд 415, 2-р тунд 931, 3-р тунд 8429(37,6%), 4-р тунд 12632 (56,4%) хүн хамрагдсан байна. Мөн 2-р тунгийн хамралт 0,1%, 3-р тунгийн хамралт 0.2%, 4-р тунгийн хамралт 0,3% тус тус нэмэгдсэн байна. Мөн улсын хэмжээнд вакцинжуулалтын байнгын 619 цэгт 1344 хүн, 87 түр цэгт 221 хүн, 576 явуулын цэгт 1852 хүн тус тус ажилласан байна. Явуулын дархлаажуулалтаар нийт 576 баг гарч сарын хугацаанд 143134 км замыг туулан 17242 хүнийг Ковид-19-ын эсрэг вакцинаар дархлаажуулсан. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | • Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Комирнэти (BNT162b2) вакцины нэмэлт тунгаар дархлаажуулах тухай А/314 дүгээр тушаалаар 12-17 насны хүүхдийг сайн дурын үндсэн дээр нэмэлт дархлаажуулалтад хамруулахаар ажиллаж эхэлсэн. | | | |
| | 42 | | 9.1.. Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Цартахлын үе шат бүрт тохирсон хариу арга хэмжээг зохицуулсан журам, зааврыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. КОВИД-19 халдварын тандалт, хариу арга хэмжээтэй холбоотой заавар 6, эмнэлзүйн удирдамж 10 удаа тус бүр шинэчлэгдсэн байна. | 100% | | |
| | 45 | | 9.5.. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цар тахлын халдварын эмчилгээнд шаардлагатай шинэ төрлийн эм, ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг түргэвчилсэн журмаар бүртгэнэ. | 2022 онд 6 аж ахуй нэгжээс улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх 16 нэрийн бодис, 4 аж ахуй нэгжээс 30 нэрийн бодисын улсын бүртгэлийн хугацаа сунгах хүсэлт ирүүлсний дагуу ЭМС-ын 2017 оны "АХУЙН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ" А/143 дугаар тушаалын дагуу бодисын материалыг хүлээн авч шинжээчийн дүгнэлт гаргуулсан. ЭМЯ-ны дэргэдэх Химийн аюулгүй байдал хордлогын менежментийг зохицуулах зөвлөлийн | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хурлаар 5 аж ахуй нэгжийн 12 сунгалт, 4 аж ахуй нэгжийн 36 өөрчлөлт, 1 аж ахуй нэгжийн 14 бодисыг шинээр хэлэлцэж бүртгэсэн ба тус төвийн 5 эмч шинжээчээр ажилласан. | | | |
| 15 | 48 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | ХӨСҮТ-ийн 2018-2022 оны стратеги төлөвлөгөөг 4 чиглэл, 7 зорилгын хүрээнд шинэчлэн боловсруулсан ба байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулж албан тасгуудад тухайн жилд хүрэх арга хэмжээг нь танилцуулсан. Коронавируст халдвар (Covid-19) болон Зонхилон тохиолдох халдварт өвчний талаар зөвлөгөө, мэдээлэл байгууллагын үйл ажиллагаа зохион байгуулалттай арга хэмжээнүүдийг тухай бүр байгууллагын www.nccd.gov.mn цахим хаяг болон facebook хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэн ажиллаж байна. | 100% | | |
| | 49 | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | - ХӨСҮТ нь халдварт өвчний хяналт, урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа, оношлогоо, эмчилгээний асуудлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв байгууллага юм.<br><br>- ХӨСҮТ-ийн бүтэц, зохион байгуулалтыг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 31 -ны өдрийн 401 тоот тушаалаар баталсан. Захирал 1, дэд захирал 3, албаны дарга 14, нэгжийн дарга 2, тасгийн эрхлэгч 36 нийт | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 783 ажилтантай ажиллаж байна.<br>- Баянзүрх дүүрэг, Нам Ян Жүгийн гудамж<br>- Утас: 453994<br>- Шуудангийн хаяг 13335<br>- Вэб хуудас www.nccd.gov.mn<br>- Сошиал хаяг “Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв” | | | |
| | 50 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 5 албан шаардлага, 5 зөвлөмж өгсөн байна. | 100% | | |
| | 51 | | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 3/2223 тоот албан бичгээр Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн. | 90% | | |
| | 52 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Байхгүй. | - | | |
| | 53 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | - Монгол улсын үндсэн хууль<br>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль<br>Төрийн албаны тухай хууль<br>Төсвийн тухай хууль<br>Хөдөлмөрийн тухай шинэчилсэн | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | найруулга<br>Эрүүл мэндийн тухай хууль<br>Авлигын эсрэг хууль<br>Дархлаажуулалтын тухай хууль<br>Зөрчлийн тухай хууль<br>Нийгмийн даатгалын тухай хууль<br>Төрийн аудитын тухай хууль<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай<br>Шилэн дансны тухай хууль<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль<br>Төрийн болон албаны нууцын тухай хууль<br>- Төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдэлийг засгийн газрын 2018 оны 382, үндсэн цалинг засгийн газрын 2022 оны 107, сүрьеэгийн нэмэгдэлийг засгийн газрын 2020 оны 151 тогтоолын 7 дугаар хавсралтын үндэслэн олгогддог. | | | |
| | 54 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Хүний нөөцийн баримт бичгийн бүрдлийг албан тушаал тус бүрээр баяжуулалт хийн хадгалсан.<br>Хүний нөөцийн албаны дарга<br>Жадамбаа Баярсайхан<br>Утас 451186<br>j.bayarsaikhan@nccd.gov.mn | | | |
| | 55 | | 8.2.8. өргөдөл, гомдлын | 2022 онд 189 өргөдөл, гомдол ирсэнээс | 90% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | - Шийдвэрлэж хариу өгсөн 171<br>- Хугацаа хэтрүүлсэн 1<br>- Хугацаа болоогүй 18 байна.<br>Шийдвэрлэлтийн байдал 90%<br>Ирсэн өргөдөл, гомдлыг агуулгаар нь авч үзвэл<br>- Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой 56<br>- Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой 34<br>- Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой 11<br>- Улирал, цаг үеийн шинжтэй зонхилж байгаа асуудал (Ковид ПСР) 69<br>- Бусад 19 | | | |
| | 56 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | 2022 онд стационарт 15489 хүн хэвтэж эмчлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3986 тохиолдол буюу 25.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. Дундаж ор хоног 8.8 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3-аар буурсан, орны эргэлт 28.3 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7 ор хоногоор өссөн үзүүлэлттэй байна. Нас баралт 171 тохиолдол байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 56 тохиолдол буюу 24.7%-иар буурсан | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үзүүлэлттэй байна. Амбулаторийн үзлэг 77326 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 125 тохиолдол буюу 0.2%-иар буурсан үзүүлэлттэй байна. | | | |
| | 57 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Нэгдүгээр сар<br>Томуу томуу төст өвчин/ Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 5<br>• Постер зөвлөгөө - 18<br>• 7 хоногийн тойм мэдээ -5<br>• Зөвлөгөө шторк – 1<br>• Vlog - 1<br>• Их эмч нэврүүлэг -1<br>Хоёрдугаар сар<br>Хоолны хордлого/Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 4<br>• Постер зөвлөгөө - 13<br>• 7 хоногийн тойм мэдээ - 4<br>• Зөвлөгөө шторк – 2<br>• Их эмч нэврүүлэг -1<br>Гуравдугаар сар<br>Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 4<br>• Постер зөвлөгөө - 52<br>• 7 хоногийн тойм мэдээ -5<br>• Зөвлөгөө шторк – 2<br>• Их эмч нэврүүлэг -1<br>Дөрөвдүгээр сар | - | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тууралтат халдвар /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 4<br>• Постер зөвлөгөө - 15<br>• 7 хоногийн тойм мэдээ -4<br>• Зөвлөгөө шторк – 2<br>• Их эмч нэврүүлэг -1<br><br>Тавдугаар сар<br><br>Дархлаажуулалтын 10 хоног Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 5<br>• Постер зөвлөгөө - 36<br>• 7 хоногийн тойм мэдээ -5<br>• Зөвлөгөө шторк – 2<br>Зургаадугаар сар<br><br>Хачигт халдвар, хоолны хордлого /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 4<br>• Постер зөвлөгөө - 16<br>• 7 хоногийн тойм мэдээ -4<br>Долоодугаар сар<br><br>Вирүст гепатиттай тэмцэх өдөр /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 4<br>• Постер зөвлөгөө - 26<br>• 7 хоногийн тойм мэдээ -4<br>Наймдугаар сар | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хоолны хордлого /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 5<br>• Постер зөвлөгөө - 16<br>• 7 хоногийн тойм мэдээ -4<br>Есдүгээр сар<br><br>Дэлхийн талбарын тархвар судлалын өдөр /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 4<br>• Постер зөвлөгөө - 23<br>• 7 хоногийн тойм мэдээ -4<br>Аравдугаар сар<br><br>Дархлаажуулалтын 10 хоног /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br>• Цаг үеийн байдлаад Live – 4<br>• Постер зөвлөгөө - 33<br>• 7 хоногийн тойм мэдээ -5<br>Араваннэгдүгаар сар<br><br>"Антибиотикийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх" дэлхийн 7 хоног /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд<br><br>• Цаг үеийн байдлаад Live – 5<br>• Постер зөвлөгөө - 9<br>• 7 хоногийн тойм мэдээ -6<br>• Зөвлөгөө шторк – 13<br>Араваннэгдүгаар сар<br><br>Дэлхийн ДОХ-той тэмцэх өдөр /Ковид-19/ халдвараас сэргийлэх сэдвийн хүрээнд | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | • Цаг үеийн байдлаад Live – 2<br>• Постер зөвлөгөө - 3<br>• 7 хоногийн тойм мэдээ -3<br><br>Нийт<br><br>• Цаг үеийн байдлаад Live – 50<br>• Постер зөвлөгөө - 260<br>• 7 хоногийн тойм мэдээ -52<br>• Зөвлөгөө шторк – 40<br>• Vlog - 1<br>• Их эмч нэвргүүлэг -4<br>• Залруулга мэдээлэл -10 #factcheck хийгдсэн.<br><br>Олон улсын дэмжлэгтэй хийгдсэн ажил<br><br>1. SARS-Cov2 вирусийн эсрэг вакцины бүрэн тун болон нэмэлт тунд иргэдийг хамруулах мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх замаар коронавируст халдварын тархалтыг бууруулах, халдвараас сэргийлэх сурталчлахад ажлын хүрээнд.<br>Дархлаажуулалттай холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэлээ :<br><br>**1.** Цуврал видео - 18 хийж нийт 788265 хүнд хүрсэн<br>**2.** Зөвлөмж мэдээ, мэдээлэл 7 удаа - 100713 хүнд хүрсэн<br>**3.** Live 20865 хүнд хүрсэн.<br>**4.** Сошиал постер - 25 боловсруулан түгээсэн.<br>**5.** Хэвлэмэл постер - 10 нэр төрлийн постерийг тус бүр 3800 ширхэг нийт 38000 ширхэгийг | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэвлүүлж 21 аймгийн дархлаажуулалтын цэгүүдэд түгээхэд бэлдээд байна. Үүнд :<br>Аймаг : Архангай 23, Баян-Өлгий 21, Баянхонгор 25, Булган 19, Говь-Алтай 22, Говьсүмбэр 6<br><br>Дархан-Уул 9, Дорноговь 19, Дорнод 18, Дундговь 16, Завхан 28, Орхон 10, Өвөрхангай 24, Өмнөговь 18, Сүхбаатар 16, Сэлэнгэ 28, Төв 30, Увс 25, Ховд 23, Хөвсгөл 29, Хэнтий 26<br><br>Дүүрэг : Баянзүрх 29, Баянгол 28, Багануур 1, Багахангай 1, Сүхбаатар 16, Сонгинохайрхан 29, Налайх 9, Хан-уул 22, Чингэлтэй 17 дархлаажуулалтын цэгүүдэд тус тус түгээнэ.<br><br>2. Улирлын томуу, томуу төст өвчний бэлэн байдлыг хангах эрсдэлийн харилцааны чиглэлээр үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд:<br>Олон нийтийн сошиал сувгууд ХӨСҮТ-ийн Фейсбүүк хуудсаар : Томуугаас сэргийлье! Цуврал 20 контент түгээн нийт Боловсролын ерөнхий газартай хамран Ерөнхий боловсролын 843 сургууль, Цэцэрлэг-1253, Их дээд сургууль-64, коллеж-76, ӨМТ, Аймаг дүүргийн эрүүл мэндийн газруудын цахим суваг анги тэнхимийн дэлгэцээр түгээн 460.337 (11 сарын эхний 7 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдлаар) хүнд хүргэн ажиллаж байна.<br>Цаашид Томуу, томуу төст өвчинтэй холбоотой ард иргэдэд зорилтод бүлгүүдэд чиглэсэн цуврал контентыг Боловсролын ерөнхий газартай хамтран Их дээд сургуулийн 547 эмч, Цэцэрлэгийн 600 нийгмийн ажилтан, их дээд сургуулийн 41 эмч, ,коллежийн-53 эмч эрүүл мэндийн ажилчдад мэргэжил арга зүйг зөвлөгөө өгөх сургах хамтын ажиллагааг бэхжүүлэхээр төлөвлөн ажилж байна. | | | |
| | 58 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | 7 төрлийн сул ажлын байрны зарыг байгууллагын сайт болон бусад цахим сайт дээр зарлаж 30000 гаруй хүн харсан байна. | 100% | | |
| | 59 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Төвийн ерөнхий захирлын 2017 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн А/6 дугаар тушаалаар баталсан ажилтан сонгон шалгаруулах журмын дагуу тус онд 44 ажилтныг ажилд авсан. | 100% | | |
| | 60 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/406 дугаар тушаал болох “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | | |
| | 61 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Төвийн захирлын А/2 тоот тушаалаар “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хөдөлмөрийн дотоод журам” , А/41 дугаар тушаалаар “Ажилтныг илүү цагаар болон амралтын өдөр | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллуулах, нэмэгдэл хөлс олгох журам", А/153 дугаар тушаалаар "Төвийн нууц хамгаалах журам", А/227 дугаар тушаалаар "Шинэ ажилтныг чиглүүлэх журам", | | | |
| | 62 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Төвийн захирлын 2022 оны 10 дугаар сарын 28-ны А/256 дугаар тушаалаар "Мэдээллийн ил тод байдлыг хангах журам" шинээр батлав. | 100% | | |
| | 63 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Төвийн захирлын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн Ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журмын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай А/209 дугаар тушаал дагуу албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж 2022 оны 1-р улиралд 728 хүнд 322,715,028 төгрөг, 2-р улиралд 748 хүнд 637,022,192 төгрөг, 3-р улиралд 688 хүнд 257,126,707 төгрөгийн урамшуулал олгоод байна. | 100% | | |
| | 64 | | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Байгууллагын www.nccd.gov.mn цахим хуудасны "ил тод байдал" хэсэг болон шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь байршуулж хэвшсэн. | 100% | | |
| | 65 | | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Байгууллагын www.nccd.gov.mn цахим хуудасны "ил тод байдал" хэсэг болон шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байршуулж хэвшсэн. | | | |
| | 66 | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Байгууллагын www.nccd.gov.mn цахим хуудасны “ил тод байдал” хэсэг болон шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь байршуулж хэвшсэн. | 100% | | |
| | 67 | | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь байршуулж хэвшсэн. | 100% | | |
| | 68 | | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь байршуулж хэвшсэн. | 100% | | |
| | 69 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Байгууллагын www.nccd.gov.mn цахим хуудасны “ил тод байдал” хэсэг болон шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь байршуулж хэвшсэн. | 100% | | |
| | 70 | | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Байгууллагын www.nccd.gov.mn цахим хуудасны “ил тод байдал” хэсэг болон шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь байршуулж хэвшсэн. | 100% | | |
| | 71 | | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, | Шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь байршуулж хэвшсэн. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | | | | |
| | 72 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Байгууллагын www.nccd.gov.mn цахим хуудасны “ил тод байдал” хэсэг болон шилэн дансны www.shilendans.gov.mn сайтанд тухай бүр хугацаанд нь байршуулж хэвшсэн. | 100% | | |
| | 73 | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалын хавсралтаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу жилийн эхэнд төлөвлөгөөг батлуулж, цахимд нийтлэн ЭМЯ болон СЯ-аар батлуулан ажилласан.<br><br>Жилийн хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ОУ-ын байгууллагын хандив тусламж, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар шалтгаалж нийт 6 удаа өөрчлөлт орсон байна.<br><br>Гэрээт Өглөөний сонинд худалдан авах ажиллагааны бүх зарыудыг нийтэлдэг ба тендер шалгаруулалтын мэдэгдлийг хуулийн хугацаанд үндэслэлүүдийн хамт гаргаж цахимд байршуулан ажилласан. | 100% | | |
| | 74 | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ | Санхүүгийн аудит хийсэн Нью эстимэйтор Аудит ХХК-д 2021 оны | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | жилийн эцсийн болон 2022 оны хагас жилийн, жилийн эцсийн худалдан авах ажиллагаатай холбоотой тайлангуудаа гарган хүргүүлж аудит хийгдсэн, Аудитын тайлан, дүгнэлт байгууллагын цахим шилэн дансад байршсан байна. | | | |
| | 75 | | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Байхгүй | | | |
| | 76 | | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Төв нь 2022 онд ДЭМБ-ын 47 төсөл, Глобаль сангийн 21 төсөл, НҮБ-ын 6 төсөл, бусад ОУБ-ын 5 төсөл хэрэгжүүлж байна.<br>- Австралийн Мурдокын хүүхдийн судалгааны төв **473,083,000**<br>- АНУ-Австрали 55,133,188.32<br>- АНУ-Вакцинити ХХК 363,391,642.6<br>- АХБ, ЯБЯС-ийн төсөл 180,015,000<br>- Глобаль сан 1,836,617,876.40<br>- ДЭМБ 2,954,938,349.10<br>- НҮБ Хүүхдийн сан 543,235,985<br><br>Шинжлэх Ухаан Технологийн Сан 105,000,000 санхүүжилтийг тус тус зарцуулсан байна. | 100% | | |
| | 77 | | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний | байхгүй | - | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайлан; | | | | |
| | 79 | | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | 2022 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн А/184 тоот тушаалаар Төлбөртэй тусламж үйлчилгээний журмыг шинэчлэн баталж үйлчлүүлэгчдэд 4 төрлийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр төлбөртэй үйлчилгээ үзүүлж байна. Уг журмаар аж ахуй нэгж байгууллагатай гэрээгээр урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах харилцааг мөн зохицуулж өгсөн ба үйлчлүүлэгч, харилцагчид эмч, мэргэжилтнүүдэд шууд төлбөр төлөх боломжгүй бөгөөд тус төвийн төрийн сангийн дансанд төлбөрийг төлөх эсхүл цахим бүртгэлийн ажилтанд төлбөр төлөх байдлаар харилцааг зохицуулсан байна. | 100% | | |
| | 80 | | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | Тус төвийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 2026 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хугацаатай.<br>Тусгай зөвшөөрөл эзэмшигч: Халдварт өвчин судлалын үндэсний төв<br>Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14 хороо, Нам Ян Жүгийн гудамж | 100% | | |
| | 81 | | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа | Эрүүл мэндийн сайдын 2021.11.30-ны өдрийн А/736 дугаар тушаалаар | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг баталсан. Батлагдсан удирдамжинд тусгагдсаны дагуу Дархлаажуулалтын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн үндэслэл, нотолгоог боловсруулж, ажлын хэсгээр хэлэлцүүлж, холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж санал авсан. Хуулийн үзэл баримтлалыг хууль зүй, эрүүл мэнд, сангийн сайдаар батлуулж, 15 Яаманд хүргүүлж, санал авч, нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2022.11.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. | | | |
| | 83 | | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | Нэмэлт өөрчлөлт ороогүй. | - | | |
| | 84 | | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Баянзүрх дүүргийн 14 хорооны нутаг дэвсгэр дэх 82990мк газар, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр Чулуутын аман дахь газар, Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр Хөшигтийн хөндий дэх газар зэргийг тус тус эзэмшдэг. | 100% | | |
| | 86 | | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон | Ерөнхий захирлын 2021 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн А/245 тоот | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | тушаалаар Төвийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан ба үүнд:<br><br>Дарга: Ерөнхий захирал Цолмонгийн Билэгтсайхан ts.bilegtsaikhan@nccd.gov.mn<br><br>Удирдах зөвлөлийн гишүүд:<br>1. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал Ж.Байгалмаа j.baigalmaa@nccd.gov.mn<br>2. Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал d.bayarsaikhan@nccd.gov.mn Д.Баярсайхан<br>3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал ts.chinbayar@nccd.gov.mn Ц.Чинбаяр<br>4. Санхүү бүртгэлийн албаны дарга g.khunzaya@nccd.gov.mn Г.Хунзаяа<br>5. Хүний нөөцийн албаны дарга j.bayarsaikhan@nccd.gov.mn Ж.Баярсайхан<br>6. Хангамж үйлчилгээ техник технологийн албаны дарга n.batnyam@nccd.gov.mn Н.Батням<br>7. Чанарын албаны дарга b.batsukh@nccd.gov.mn Б.Батсүх<br>8. Сувилахуйн албаны дарга | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | n.norovjargal@nccd.gov.mn Н.Норовжаргал<br>9. Сургалтын албаны дарга j.bayarsaikhan@nccd.gov.mn Ж.Баярсайхан<br>10. Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл гэсэн бүтэц бүрэлдэхүүнтэй байна. | | | |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |
| | 106 | | 2.6/. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын вакциныг эхний ээлжид худалдан авах чиглэлээр олон улсын холбогдох байгууллагуудтай гэрээ хэлэлцээр байгуулах; | Монгол улсын хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг 4 төрлийн (АстраЗенека, Файзер/БиоНТех, Спутник-V, Вероцелл) 8,699,950 тун вакциныг 4 эх үүсвэрээс хүлээн авснаас ХӨСҮТ-д 8,620,150 тун вакциныг хүлээн авч аймаг, дүүрэгт түгээж зорилтот бүлгийн хүн амыг вакцинжуулах ажлыг зохион байгуулсан. | 100% | | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| | 149 | Чиглэл өгөх тухай 2020-02-19 Дугаар 2020 №01 АБГББХ | 1.1.б/. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран халдвараас урьдчилан сэргийлэх, хяналтыг сайжруулах талаарх хамтын ажиллагааг өргөжүүлэх; | КОВИД-19 цартахалтай холбоотой ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газартай хамтран "КОВИД-19 цартахлын дараах тогтвортой байдлын төлөвлөгөө боловсруулах", МУ-ын шадар сайдын 08 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах ажлууд хийгдэж тушаалын төсөл боловсруулан Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн бөгөөд 2023 онд хийгдэхээр хугацаа хойшлогдсон болно. | 50% | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 38 | 165 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/ 2020-02-12 Дугаар 2020_10 | 1. 1. Дэлхийн олон улс болон манай хөрш БНХАУ-д шинэ коронавирусийн тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл болгосугай: 1.1. Шинэ коронавирусийн тархалтын нөхцөл байдалтай уялдуулан хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэглэлийг үе шаттайгаар сонгон хэрэгжүүлэх шийдвэр гаргах; 1.2. Олон улсын хөл хориот болон халдварт бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин гарсан үед тархаахгүй байх, таслан зогсоох зорилгоор хорио цээрийн дэглэм тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар яаралтай хэлэлцэн журамлаж, мөрдүүлэх; 1.3. Цагаан сарын баярт зориулсан олон нийтийг хамруулсан үзэсгэлэн худалдаа, мэдээллийн хэрэгслээр явуулах реклам, | ХӨСҮТ нь КОВИД-19 өвчлөлийн тоон мэдээллийг өдөр тутам нэгтгэн уг мэдээллийг ҮАБЗ, УОК, ЭМЯ-д хүргүүлэн ажилласан. Мөн 7 хоног тутам КОВИД-19 нөхцөл байдлын тойм мэдээлэл бэлтгэж холбогдох байгууллагууд болон аймаг, орон нутагт хүргэж байна. Шинэ бүртгэгдэж байгаа тохиолдлуудын тархвар судалгааг хийж, тандалтын тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажиллаж байна. КОВИД-19 өвчлөлийн нөхцөл байдал, цартахлын үе шат бүрт тохирсон хариу арга хэмжээ авах журам зааврыг холбогдох байгууллагаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгаа, эрсдэлийн үеийн харилцааг сайжруулах чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэн зөв мэдээлэл өгөх, иргэдийг зөв мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сурталчилгааг даруй зогсоох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх иргэдийн үүрэг, хариуцлага, уг халдварын хор хөнөөлийг ухуулан ойлгуулах ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах; 1.4. Дэлхий дахинд хүнээс хүнд, мал, амьтнаас хүнд халдварлах халдварт өвчин ихээр тархах болсонтой холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай болон бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулган, шаардлагатай бол ээлжит бус чуулганаар яаралтай горимоор хэлэлцүүлэх. 2. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүргээ ухамсарлан, өөрийн болон нийтийн эрх ашгийг эрхэмлэхийг нийт ард иргэдэд уриалсугай. | | | | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | |
| 42 | 173 | Халдварт өвчний өнөөгийн | 1. 1. "Дархлаажуулалтын тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/736 дугаар тушаалаар Дархлаажуулалтын тухай | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдал, хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2010-03-19 Дугаар 2010_11/06 | худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай", "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, вакцины нийлүүлэлт, эм, хүнсний зохицуулалтын бие даасан алба байгуулах, хөндлөнгийн хяналтыг тодорхой болгох, зарим эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин тоног төхөөрөмжийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрээс шууд худалдан авах бололцоог бүрдүүлэх, улсын хэмжээнд вакцин, биобэлдмэлийн хөндлөнгийн хяналтын лаборатори байгуулах, төрийн хяналтыг чангатгах, хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх, | хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг баталсан. Батлагдсан удирдамжинд тусгагдсаны дагуу Дархлаажуулалтын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн үндэслэл, нотолгоог боловсруулж, ажлын хэсгээр хэлэлцүүлж, холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж санал авсан. Хуулийн үзэл баримтлалыг Хууль зүй, Эрүүл мэнд, Сангийн сайдаар батлуулж, нийт 15 яаманд хүргүүлж, санал авч, нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн болно. | | | |
| ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 46 | 188 | Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03 | 6. . Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий | Төвийн хэмжээнд мөрдөх гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг БЗД-ийн ОБГ-аар батлуулан, жил бүр тодотгол хийн ажиллаж байна. Үүнд: мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, сэргээн босгох болон сургалтын төлөвлөгөөнүүдийг боловсруулсан. 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр БЗД-ийн ОБГ-тай хамтран үзүүлэх сургуулийг зохион | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга) | байгуулсан. | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 68 | 215 | 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2021-09-22 Дугаар 2021_52 | I.5. Хилийн Гашуунсухайт боомт, Цагаан хадны суурьшлын бүсэд түр оршин суугаа иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагыг харгалзан Өмнөговь аймгийн Ханбогд сумын Эрүүл мэндийн төвийн харьяа “Их эмчийн ортой салбар”-ыг Хайрхан багт шинээр байгуулахад шаардлагатай зардлын тооцоог хийж, 2022 оны төсвийн төсөлд тусгах талаар холбогдох арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав. | Гашуун сухайт боомтод тандалт судалгаа, лабораторийн чиглэлээр 12-16 эмч мэргэжилтэн багтсан багийг тасралтгүй ажиллуулсан ба 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нийт 31 баг ажилласан байна. | 100% | | |